

# Contents

- 2 日本語版
- 4 Bản tiếng Việt [ベトナム語版]
- 6 中文版 [中国語版]
- 8 Bersyon sa Pilipino [フィリピン語版]
- 10 Edisi Bahasa Indonesia [インドネシア語版]
- 12 ฉบับภาษาไทย [タイ語版]
- 14 ភាសាខ្មែរ [カンボジア語版]
- 16 မြန်မာဘာသာ မူ [ミャンマー語版]
- 18 Монгол хэл дээрх хувилбар [モンゴル語版]
- 20 English Version [英語版]

## こくごのもり

小学低学年の児童を対象に国語の楽しさを知ってもらおうと、イラストを多用してつくった問題で「毎日小学生新聞」に長期連載。

©毎日小学生新聞 複製、転用はできません

「お」か「こ」につながる言葉を下からえらんで書きましょう。  
全部書けたら声に出して読みましょう。

指導・元世田谷区立  
小学校教諭  
高橋 侖子  
イラスト・奈良 恵

「お」か「こ」

親切 きげん となり 楽しみ 苦労 乗車 いわい 仕事 元気 あいさつ 考え 知らせ ちそう 茶はん

答えはP22にあります。

# Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр

2020 оны 7-р сар, зуны дугаар

## Зуны улиралд анхаарах зүйлс - Дулааны цохилт болон гамшгаас хамгаалцгаая

Сүүлийн жилүүдэд Японд зундаа агаарын температур 35 хэмээс дээш болж халах маш халуун өдөр хэдэн өдрөөр үргэлжлэх, Турпооп буюу хар салхи, хүчтэй аадар бороо зэргээс улбаалсан байгалийн гамшиг их хэмжээгээр гарч байна. Үүнтэй холбогдуулан Японы зуны улиралд анхаарах зүйлсийн талаар нэгтгэн танилцуулж байна. Ур чадварын дадлагажигч та бүхэн дараах мэдээллийг өөрсдийнхөө эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалахад ашиглана уу.

**Дулааны цохилт** Дулааны цохилт гэдэг нь агаарын температур өндөр, чийгшилт ихтэй нөхцөлд хүний биеийн шингэн болон давсны тэнцвэр алдагдсанаас үүсдэг өвчин юм. Дулааны цохилтын талаар сайн мэдэж аван, өөрийнхөө биеийн байдалд гарч буй өөрчлөлтөд анхаарахын зэрэгцээ эргэн тойрныхоо хүмүүст санаа тавьж, дулааны цохилтоос урьдчилан сэргийлцгээе.

<Дулааны цохилтын шинж тэмдэг> **Дотор муухай оргих, толгой эргэж дайвалзах, хөл, гар бадайрах, толгой өвдөх, чичрэх гэх мэт.** Хүндэрсэн тохиолдолд, хүний асуултанд сонин жигтэй хариу өгөх, ухаан алдах гэх мэт шинж тэмдгүүд илэрнэ.

<Дулааны цохилтоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ>

● Гадагшаа гарах үед

☑ **Усны сав ашиглан, уух юм биедээ авч явахыг дадал болгож, ойр ойрхон шингэнээ нөхөх.**

Амаа цангахаас өмнө ус уух, их хэмжээгээр хөлөрсөн үед бол уснаас гадна давс бас авах нь чухал юм.

☑ **Малгай өмсөх, нарны шүхэр барих зэргээр нарны хурц тусгалаас зайлсхийх.**

● Байнга анхаарах зүйлс

☑ **Гэртээ байхдаа агааржуулагч болон сэнс хэрэглэж, өрөөгөө сэрүүхэн байлгах.**

☑ **Өөрийнхөө байгаа орчны дулааны цохилтын аюулын талаар байнга анхааралдаа авахыг хэвшил болгох нь чухал юм.**

<Өөрөө болон найз нөхөд тань дулааны цохилтонд өртсөн үед>


☑ Сэрүүн, сүүдэр газар юм уу агааржуулагч асаасан өрөө рүү шилжих.

☑ Шингэн болон давс нөхөх.

☑ Өмссөн хувцсаа сул тавьж, биеэ хөргөх.

➢ **Найз нөхөд тань өөрөө ус уух чадалгүй, ухаан алдсан тохиолдолд, шууд түргэн тусламж (Утасны дугаар: 119) дуудах!**

Дулааны цохилтын аюулын түвшнийг илэрхийлдэг "Халууны индекс"-ийг шалгах!

 <https://www.wbgt.env.go.jp/>

Цаг уурын агентлагийн

"Дулааны цохилтоос урьдчилан сэргийлэх мэдээллийн сайт"



**Турпооп буюу хар салхи, хүчтэй аадар борооноос улбаалсан үер, усны гамшиг** Японд, ялангуяа 7-10 дугаар сард Турпооп буюу хар салхи Японы аралд ойртон ирэх, Японы арлыг дайрах нь ихэсдэг ба хөрсний гулгалт зэрэг их хэмжээний хохирол учруулдаг. Нөгөөтэйгөөр, Гамшгаас сэргийлэх цаг уурын мэдээг ашиглан, хохирлоос урьдчилан сэргийлэх, хохирлыг бууруулах боломжтой тул, хүн бүр хар салхины аюулын талаар мэдэж, өөрсдийгөө хамгаалахыг хичээх нь чухал юм.

<Урьдчилан мэдэж авах зүйлс>

☑ Өдөр тутамд телевизор, радио зэрэг хэрэгслийг ашиглан, цаг агаартай холбоотой мэдээлэл олж авах.

☑ Хот / дүүрэг / бичил хот / тосгоноос гаргадаг "Аюулын зураглал"-аас аюултай газар болон нүүн шилжих газрыг харж, мэдэж авах.

☑ Нүүн шилжих газар хүртэлх замын дарааллыг шалгаж, мэдэж авах.

☑ Өдөр тутмын амьдрал ахуйд дэмжлэг үзүүлэх зөвлөгч болон хамт ажилладаг нөхөдтэйгөө гамшиг гарсан үед хоорондоо хэрхэн холбоо барих талаар ярилцаж, тохирох.

<Турпооп буюу хар салхи ойртож ирсэн үед>

☑ Хүчтэй салхиж байгаа үед аль болох гадагшаа гарахгүй байх.

☑ Их хэмжээний бороо үргэлжлэн орвол, голын ус эргээсээ халих, хөрсний гулгалт үүсэх аюултай.

Хот / дүүрэг / бичил хот / тосгоноос нүүн шилжихэд бэлтгэх заавар гарсан үед, хэзээ ч нүүн шилжиж эхлэхэд бэлэн байхуйцаар бэлтгэлтэй байх.


☑ Голын ус нэмэгдсэн, далайн давалгаа өндөр байгаа үед гол, далай нь маш аюултай. Хэрхэвч ойртож болохгүй.

➢ **Турпооп буюу хар салхитай үед хар салхи дайраад өнгөрсний дараа ч хүчтэй салхилах, бороо орсоор байх тохиолдол байдаг. Түгшүүрийн дохио болон сэрэмжлүүлэг тайлагдтал анхаарал болгоомжтой байх.**

**Засгийн газраас цаг агаарын мэдээ, үер, хөрсний гулгалт зэрэг мэдээллийг цацдаг. Ойр ойрхон шалгаж, зуны улиралд гарах гамшгаас өөрсдийгөө хамгаалцгаая.**

Гамшгийн үед мэдээлэл түгээх аппликейшн "Safety tips" [11 орны хэлээр мэдээлнэ.]

Цаг агаартай холбоотой түгшүүрийн дохионы мэдээлэл болон газар хөдлөлтийн мэдээлэл, дулааны цохилтын мэдээлэл зэрэг мэдээллийг харах боломжтой.

 <https://disaportal.gsi.go.jp/>  
Газар, дэд бүтэц, зам тээвэр, аялал жуулчлалын яамны "Аюулын зураглал портал сайт"



**Далайн усанд орох үеийн осол** Далайгаар хүрээлэгдсэн орон Японд зун болохоор, энд тэндгүй, ээлж дараалан "Усан сэлэлтийн улирлын нээлт" болдог. Ялимгүй багахан сонор сэрэмж алдагдсанаас далайн усанд орох хөгжилтэй мөчийг том хэмжээний осолд хүргэх аюултай. Аюулгүйгээр далайн усанд орж хөгжилдөхийн тулд дараах зүйлсийн талаар анхаараарай.

☑ Далайн усанд орохынхоо өмнө заавал бие халаалт хийх.

☑ Аюултай бөгөөд орж болохгүй газрыг "Сэлэхийг хориглосон бүс" гэдэг. Тус бүсэд ойртож болохгүй.

☑ Биеийн байдал тааруу байгаа үе болон согтууруулах ундаа уусан үед сэлэхээ болих.

☑ Цаг агаар муу байгаа үед хүчээр далайд орохгүй байх нь чухал.

## Ур чадварын дадлагажигч нарт зориулсан шинэ төрлийн коронавируст халдварын талаарх мэдээлэл

Шинэ төрлийн коронавируст халдварын талаар Ур чадварын дадлагажигч та бүхэнд хэрэг болох сайтуудыг танилцуулъя. Төрийн байгууллагууд болон бусад холбогдох байгууллагуудаас гадаадын олон хэл дээр гаргасан материал, анхан шатны Япон хэл дээр бичигдсэн материалууд тавигдсан байна.

Танилцуулж буй сайтуудад мэдээлэгдсэн мэдээлэл болон URL хаяг нь шинэчлэгдэх магадлалтайг ойлгоно уу.

- 🌐 **Шинэ төрлийн коронавируст халдвараас сэргийлэх тухай болон бусад** (Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага)

Ур чадварын дадлагажигч нарт зориулсан эх хэл дээр нь гаргасан халдварлалтаас сэргийлэх тухай мэдээллээс гадна эх хэл дээрээ зөвлөгөө авах газрын талаарх мэдээлэл тавигдсан байна.

<https://www.otit.go.jp/notebook/>

- 🌐 **Шинэ төрлийн коронавируст халдвараас хамгаалахад - Хүн нэг бүрийн авч чадах арга хэмжээний талаар мэдэж авцгаая** - (Ерөнхий сайдын албаны өргөө)

Зайлсхийх хэрэгтэй 3 нөхцөл байдал (1. Цэвэр агаарын солилцоо муутай орчин, 2. Олон хүн бөөгнөрсөн газар, 3. Ойрхон зайнаас хүнтэй харилцан ярилцах нөхцөл байдал), гараа хэрхэн зөв угаах, ханиалгахад баримтлах ёс зүй зэргийн талаар Англи хэл болон Хятад хэл дээрх мэдээллийн хуудсыг ашиглах боломжтой.

<https://www.kantei.go.jp/jp/headline/kansensho/coronavirus.html>

- 🌐 **Шинэ төрлийн коронавирусын тухай** (Орон нутгийн захиргааны байгууллагуудын олон улсын харилцааны Зөвлөл)

Анхан шатны Япон хэл болон гадаад хэл дээр мэдээлэл тавигдсан байна. Гар угаах тухай зурагтайгаар харах боломжтой.

<http://www.clair.or.jp/tabunka/portal/info/contents/114517.php>

- 🌐 **Гадаадын иргэдэд зориулсан өдөр тутмын амьдрал ахуйд дэмжлэг үзүүлэх портал сайт** (Хууль зүйн яам)

[http://www.moj.go.jp/nyuukokukanri/kouhou/nyuukokukanri10\\_00055.html](http://www.moj.go.jp/nyuukokukanri/kouhou/nyuukokukanri10_00055.html)

- 🌐 **AMDA Олон улсын анагаах ухааны мэдээллийн төв**

Гадаадын иргэдэд эмнэлгийн байгууллагын талаар мэдээлэл олгох, утсаар эмнэлгийн мэргэжлийн орчуулгын үйлчилгээ үзүүлдэг байгууллага ба шинэ төрлийн коронавирусын талаар гадаадын олон хэл дээр зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлж байна.

<https://www.amdamedicalcenter.com/>


- 🌐 **Компанид ажиллаж буй гадаадын иргэдэд зориулсан мэдээлэл** (Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам)

Шинэ төрлийн коронавирусын нөлөөгөөр компанийн үйл ажиллагаа нь саарсан тохиолдолд ч, гадаадын иргэн гэдэг шалтгаанаар ажил эрхлэгч гадаадын иргэнд Японы иргэнээс ялгаварлаж хандах нь зөвшөөрч болшгүй зүй бус зүйл болох талаар гадаад хэл дээр мэдээлэл тавигдсан байна.

[https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/koyou\\_koyou/jigyounushi/page11\\_00001.html](https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/koyou_koyou/jigyounushi/page11_00001.html)

### Мангагаар дамжуулан мэдэж авцгаая, Япон хүний сэтгэл

— Гэрээсээ харъя —



#### Гэрээсээ голын байдлыг харж буй Маруй сан

Турпоон буюу хар салхи болон их хэмжээний бороо орж байгаа үед гадаах байдлыг мэдэхийн тулд гэрээсээ гарах нь маш аюултай. Гадагшаа гарах аюултай үйлдлээс зайлсхийж, орчин үеийн нийгэмд байгаа ач тустай хэрэгслүүдийг зөв ашиглаж, хэрэгтэй мэдээллээ олж авцгаая.



◆ここここたえ



「お」も「ご」も言葉の上につけて、尊敬やていねいの意を表す働きをします。漢字は「お・ご」とも「御」です。「お」は、「おほんおんお」となり、ました。「源氏物語」は、「いつれの御時にか…」で始まります。「ご」は漢語につきますが、「元氣」に「ご」はつけません。自身でなく相手への心遣いが、やわらかい「お」をつけさせたのでしょう。

Trong tiếng Nhật, khi muốn thể hiện ý kính trọng hoặc lịch sự, người ta thường đặt chữ “お” hoặc chữ “ご” trước từ muốn nói. Trong tiếng Hán, cả từ “お” và “ご” đều được viết là “御”. Chữ “お” vốn là từ “おほん”, biến âm dần thành “おん” rồi thành “お”. Trong tiểu thuyết cổ “Chuyện Genji” được bắt đầu bằng câu “いつれの御時(おほんとき)にか…” (nghĩa là: Bắt đầu từ khi nào…) Từ “ご” thường được dùng với một danh từ chữ Hán, nhưng với từ “元氣” (nghĩa là: mạnh khỏe) thì người ta lại không dùng từ này. Có thể là do muốn thể hiện sự quan tâm tới người đối diện nên người Nhật dùng từ “お” để khi nghe cảm thấy nhẹ nhàng hơn chăng.

「お」和「ご」都是添加在日语词汇的前面，起表示尊敬和礼貌之意的作用。「お・ご」的汉字都是「御」。「お」是从「おほん→おん→お」变化而来的。最早出现在《源氏物语》中的「いつれの御時(おほんとき)にか…」。「ご」一般加在汉语词汇之前，但是「元氣」的前面不能加「ご」。与自身无关，表达对对方的关心时会委婉地加上「お」。

Ang “お” at “ご” din, kapag idinagdag sa umpisa ng salita ay nagpapakita ng respeto at paggalang. Sa kanji, ang “お・ご” ay “御” rin. Ang “お” ay magiging “おほん→おん→お”. Sa Genji monogatari(源氏物語), laging naguumpisa sa “いつれの御時にか…” . Sa kango (漢語), pwedeng lagyan ng “ご” ngunit ang “元氣” ay hindi maaaring lagyan ng “ご”. Inaalala nila ang kaharap na tao kaysa sa sarili, kaya marahil nilagyan nila ng “お” upang maging malambot ang pananalita.

“O” dan “go” ditambahkan pada awal kata-kata untuk menunjukkan rasa hormat dan sopan. Huruf Kanji dari “o” maupun “go” adalah “御”. “O” mengalami perubahan “ohon → on → o”. Dalam Genji Monogatari (Hikayat Genji), kisahanya dimulai dengan “Izure no ohontokinika…” (Dalam suatu masa pemerintahan…). “Go” dipakai dalam kata yang berasal dari bahasa China, tetapi “go” tidak ditambahkan pada “genki” (sehat/bertenaga), melainkan “o” yang bernuansa lembut yang ditambahkan. Mungkin karena memberi perhatian kepada orang lain dan bukan kepada diri sendiri.

ทั้ง “お” และ “ご” ต่างเป็นคำที่ใส่ไว้ข้างหน้าคำอื่นเพื่อแสดงถึงความเคารพและสุภาพอ่อนน้อม “お・ご” ต่างเขียนด้วยตัวอักษรคันจิ “御” โดยคำว่า “お” เป็นการเปลี่ยนแปลงของเสียง “おほん→おん→お” “เรื่องเล่าของเก็นจิ” เริ่มต้นเรื่องด้วยประโยคที่ว่า “いつれの御時にか…(ในรัชสมัยหนึ่ง…)” คำว่า “御時” เป็นการแสดงความเคารพต่อพระจักรพรรดิ “ご” เป็นคำที่มาจากภาษาจีน เราจะไม่เอา “ご” ไปวางไว้หน้าคำว่า “元氣” แม้จะเป็นการแสดงความคำนึงใส่ใจที่มีต่อฝ่ายตรงข้ามก็ตาม การใช้ “お” จะให้ความรู้สึกที่อ่อนโยนกว่า

ทั้ง “お” และ “ご” ត្រូវបានបន្ថែមនៅមុខពាក្យដើម្បីបង្ហាញការគោរព និងសុភាពរាបសារ។ អក្សរកាន់ដើមរបស់ “お” ក៏ដូចជា “ご” គឺ “御” ។ “お” បានក្លាយមកពី “おほん→おん→お” ។ “រឿងនិទានហ្គេនជិ” ចាប់ផ្តើមដោយ “いつれの御時(おほんとき)にか…” ។ នៅក្នុងភាសាចិនគេដាក់ “ご” ក៏ប៉ុន្តែ “ご” មិនត្រូវបានបន្ថែមទៅ “元氣” ទេ។ ដោយសារតែមិនមែនសំដៅចំពោះខ្លួនឯង ប៉ុន្តែគឺជាការគោរពភាគីម្ខាងទៀត បានជាគេបន្ថែមពាក្យ “お” ដើម្បីឲ្យទន់ភ្លន់។

“お” ရာ “ご” ၀ ကားလုံးရဲ့ အရှေ့မှာတဲ့သုံးတာဖြစ်ပြီး လေးစား ယဉ်ကျေးသမှုရှိကြောင်း ပြပါတယ်။ “お・ご” နှစ်ခုလုံးရဲ့ ခန်းဂျိုးစာလုံးက “御” ဖြစ်ပါတယ်။ “お” ဆိုတာ “おほん→おん→お” ဆိုပြီး ပြောင်းလဲလာတာပါ။ “ဂဲန်းဂျီ မိုနိုဂါတာရီ” ဆိုတဲ့ ဝတ္ထုမှာ “いつれの御時にか…” ဆိုတဲ့စကားနဲ့ စာတ်လမ်းကို ဖွင့်ပါတယ်။ “ご” ကို တရုတ်ဘာသာ စကားလုံးတွေနဲ့ တွဲသုံးတာဖြစ်ပေမဲ့ “元氣” မှာတော့ “ご” ကို မသုံးပါဘူး။ မိမိကိုယ်ကိုယ်မဟုတ်ဘဲ တဖက်လူအပေါ် ဂရုစိုက်တဲ့သဘောနဲ့ အသံပျော့ပြောင်းတဲ့ “お” နဲ့ တွဲပြီး သုံးကြတာဖြစ်မယ်ထင်ပါတယ်။

“お”, “ご” -гийн аль аль нь үгийн эхэнд залгаснаар, тухайн үгийг хүндэтгэлтэй, эелдэг хэллэг болгох үүргийг гүйцэтгэдэг ба ханзаар бичихдээ аль алийг нь “御” гэж бичдэг. “お” нь, “おほん→おん→お” гэж өөрчлөгдөж ирсэн. “源氏物語/Гэнжигийн үлгэр” эхлэхдээ “いつれの御時(おほんとき)にか…” гэж эхэлдэг. “ご” -г Хятад хэлнээс гаралтай үгийн эхэнд залгадаг. Харин “元氣” -д “ご” залгадаггүй. Өөрийнхөө бус нөгөө хүнийхээ сэтгэлийг бодсоноос, зөөлөн сонсогддогээр нь “お” -г хэрэглэдэг болсон байж болох юм.

“お” and “ご” are prefixes that add a feeling of respect or politeness to words. In kanji, both are written as “御.” “お” was originally pronounced “おほん,” which was later simplified to “おん” and eventually “お.” The famous Tale of Genji, or Genji Monogatari, begins with the phrase, “いつれの御時(おほんとき)にか.” “ご” is usually prefixed to words of Chinese origin. However, it is not prefixed to the word “元氣.” The thoughtfulness of putting people before oneself perhaps led to using the softer “お” prefix in this case.

技能実習生・研修生向母国語情報誌 発行 公益財団法人 国際人材協力機構 (JITCO)  
**技能実習生の友** 総務部広報室  
 2020年7月 夏季号 〒108-0023  
 2020年7月1日発行 東京都港区芝浦2-11-5  
 五十嵐ビルディング  
 電話 03-4306-1166 (ダイヤルイン)  
 JITCO ホームページ https://www.jitco.or.jp/